



УДИРДАЛГЫН
АКАДЕМИ

Захиргааны шийдвэр гаргах ажиллагаа нийтлэг зөрчлүүд

Судалгаа

Шүүн таслах ажиллганы 2017 оны тайланд ЗХШ-ээр 1908 нэхэмжлэл хэлэлцсэн. Үүнээс 49 хувь буюу хариуцагч болох захиргааны байгууллагын буруу шийдвэрийг хүчингүй болгожээ.

(Шүүхийн Ерөнхий Зөвлөл)

Нийтлэг зөрчил

- Шийдвэр гаргах ажиллагааны журмыг зөрчих
- Хууль зүйн үндэслэлийг тогтоох явцад гарах зөрчил
- Мэдэгдэх, бүртгэх журмыг зөрчих

Шийдвэр гаргах ажиллагааны журмыг зөрчих

- Оролцогчийн эрхийг хангахгүй байх
- Бодит нөхцөл байдлыг хуульд заасан нотлох баримтад тулгуурлаж тогтоохгүй байх
- Сонсох ажиллагаа хийхгүй байх
- Саналыг тусгасан талаар тайлбар хийхгүй байх
- Захиргааны шийдвэрийн хувийн хэргийг бүрдүүлэхгүй байх

Оролцогчийн
эрх
/ЗЕХ 15.1/

захиргааны байгууллагыг
хуулиар хүлээсэн чиг үүргээ
хэрэгжүүлэхийг шаардах

хууль зүйн болон бусад
мэргэжлийн зөвлөгөө,
туслалцаа авч болно

мэдээлэл авах, холбогдох баримт бичгийг
хуулбарлан авах;


шийдвэрийг гаргах эрх бүхий албан
тушаалтны талаар мэдээлэл авах

өөрийн гаргаж өгсөн баримт бичгийн
баталгаажсан хуулбар болон эх хувийг буцаан
авах

нотлох баримт гаргах, шаардлагатай баримт
бичгийг бүрдүүлэн өгөх

хэрэгжүүлэхийг хүссэн төсөл, үйл ажиллагаа,
төлөвлөгөө, өргөдөл, хүсэлтийн талаар
мэдээлэл авах

захиргааны байгууллагын бүртгэл, архивын
баримттай танилцах



Мэдээлэл цуглуулах

Оролцогчийг сонсох, тайлбар гаргуулах

Шинжээч оролцуулах

Гэрч, гуравдагч этгээдээс тайлбар авах

Баримт бичиг, хууль, бусад шийдвэртэй танилцах

Туршилт хийх

НОТЛОХ
БАРИМТ
БҮРДҮҮЛЭХ
/ЗЕХ 25/

Оролцогч хуульд заасан хүрээнд нотлох баримт бүрдүүлэхэд оролцож болно

Оролцогч өөрт мэдэгдэж буй нөхцөл байдал болон нотлох баримтыг гаргаж өгөх

СОНСОХ /ЗЕХ 26-28/



Захиргааны байгууллага эрх,
хууль ёсны ашиг сонирхол
хөндөгдөж буй этгээдийг
тодорхойлох;

Эрх, хууль ёсны ашиг сонирхол
хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэл
хүргүүлэх;

Сонсох ажиллагааны
хэлбэрүүдийг сонгох.

Захиргааны акт, захиргааны гэрээг батлан
гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг
сонирхол нь хөндөгдөж болзошгүй
этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач
холбогдол бүхий нөхцөл байдлын талаар
**ТАЙЛБАР, САНАЛ ГАРГАХ БОЛОМЖ
ОЛГОНО.**



*Сонсох ажиллагааны үед гарсан
саналыг захиргааны шийдвэр
гаргах ажиллагаанд заавал тусгах
үүрэг хүлээхгүй боловч тусгаагүй
шалтгааныг тайлбарлах үүрэгтэй.*

Шийдвэрийн хувийн хэрэг /ЗЕХ 29/

- Үндэслэл
- Үе шат
- Оролцогчдын санал
- Холбогдох баримт
- Сонсох ажиллагаа
- Уулзалт
- Хуралдааны тэмдэглэл
- Шийдэл
- Хүргүүлсэн, мэдээлсэн баримт



ХЯНАЛТЫН ДАГАЛДАХ ХУУДАС /ЗЕХ 29/

- Шийдвэр боловсруулахад оролцсон албан хаагч бүрийн овог нэр, албан тушаал
- Шийдвэр боловсруулах оролцоо, гүйцэтгэлийн тухай дэлгэрэнгүй тэмдэглэсэн байна.

Хууль зүйн үндэслэлийг тогтоох явцад гарах зөрчил

- Утга агуулгын хувьд алдаатай байх
- Хуульд үндэслэх зарчмыг зөрчих

Утга агуулгын хувьд алдаатай байх

- Захиргааны актын агуулга ойлгомжгүй, хоёрдмол утгатай байх
- Ж: болно, харгалзана гэсэн үгийг хэрэглэх гм

Хуульд үндэслэх зарчмыг зөрчих

- Хуулиар бүрэн эрх олгоогүй байхад шийдвэр гаргах
- Хуулийг буруу хэрэглэх
- Хуульд заасан чиг үүргээ биелүүлэхгүй байх /эс үйлдэхүй/

Бичгээр тавигдах шаардлага

- 40.2.1.захиргааны актыг гаргасан захиргааны байгууллагын нэр, хаяг, тамга, тэмдэг болон гарын үсэг зурах эрх бүхий албан тушаалтны нэр, гарын үсэг, захиргааны актын нэр, он, сар, өдөр, дугаарыг тодорхой заасан байх;
- 40.2.2.захиргааны акт хаяглагдсан этгээд нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хаяг, холбоо барих мэдээлэл, хуулийн этгээд бол түүний нэр, хаяг, бүртгэлийн дугаар, холбоо барих мэдээлэл, хуулийн этгээдийн эрхгүй бусад этгээд бол түүний төлөөлөгч, нэр, хаяг, холбоо барих мэдээлэл;
- 40.2.3.захиргааны актыг гаргах бодит нөхцөл байдал, хууль зүйн үндэслэлийг заах;
- 40.2.4.захиргааны шийдвэр гаргах ажиллагааг өргөдөл, гомдлын үндсэн дээр үүсгэсэн бол түүнийг тусгах;
- 40.2.5.захиргааны актыг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд гомдлыг хандан гаргах этгээд болон хугацааг заах.

Мэдэгдэх журмыг зөрчих

- Захиргааны байгууллага захиргааны актыг хуульд өөрөөр заасан тохиолдолд өөрт нь гардуулах, шаардлагатай тохиолдолд утас, факс, шуудан, цахим болон бусад хэлбэрээр мэдэгдэж болох бөгөөд ийнхүү мэдэгдсэнээ баримтжуулна.
- Захиргааны актыг баталгаат шуудангаар явуулснаас хойш нийслэлд ажлын таван өдөр, орон нутагт ажлын 10 өдөр өнгөрсний дараа уг актыг мэдэгдсэнд тооцно.
- Захиргааны актын хаяглагдсан этгээд өөрийн албан ёсны хаягтаа байхгүй, хаягийн өөрчлөлтийг захиргааны байгууллагад мэдэгдээгүй, эсхүл зориуд санаатайгаар хүлээн авахаас зайлсхийсэн тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлснээс хойш ажлын 10 өдөр өнгөрсний дараах өдрийг уг актыг албан ёсоор мэдэгдсэнд тооцно.

Бүртгэх журмыг зөрчих

- Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага захиргааны хэм хэмжээний актыг бүртгэхдээ хуульд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгэнэ.

• БАЯРЛАЛАА